



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн Мөрөн сумын “Зүүн мөрөн” хорооллын 35 кВ-ын цахилгаан хангамжийн шугам сүлжээ, дэд станцын барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 3,579,344,345.00 (гурван тэрбум таван зуун далан есөн сая гурван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун дөчин таван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Хөвсгөл Эрчим хүч” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд, “Хөвсгөл Эрчим хүч” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Г.Очирхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


  
Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

  
Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000008





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 02 дугаар сарын 19 -ний өдрийн  
45... дугаар тогтоолын хавсралт

**"Хөвсгөл Эрчим хүч" орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн  
дансанд бүртгэх барилга байгууламжийн жагсаалт**

Д/д	Барилга байгууламжийн нэр, байршил	Барилга		Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)
		Эхэлсэн	Дууссан					
1	35/10 кВ-ын дэд станц тоноглол /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	506,538,697.00
2	35/10 кВ-ын дэд станцын суурийн БУА /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	126,391,531.00
3	35 кВ-ын ЦДАШ /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	191,810,159.00
4	Өндөр үелзлэлийн холбооны угсралт /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	41,770,209.00
5	10 кВ-ын ЦДАШ /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	239,627,146.00
6	РП тоноглол угсралт /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	927,399,879.00
7	2х400 кВа ХТП-1 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	102,354,145.00
8	2х400 кВа ХТП-2 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	102,354,145.00
9	Трансформатор SZ11-2000/35 35/10 кВ /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	130,000,000.00
10	Вакуум таслуур ZW7-40.5 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	50,000,000.00
11	Хуурай салгуур 35 d/1600 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	5,200,000.00
12	Хуурай салгуур 35 11D/1000 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	17,400,000.00
13	Трансформатор SC9-30/10 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	4,200,000.00



Д/д	Барилга байгууламжийн нэр, байршил	Барилга		Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)
		Эхэлсэн	Дууссан					
14	Трансформатор S11-400кВа ХТП-1 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	33,000,000.00
15	Трансформатор S11-400кВа ХТП-2 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	33,000,000.00
16	10 кВ-ын хуваарилах байгууламж КУН28А-12 /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	524,160,000.00
17	Трансформаторын хэмжүүр хамгаалалт удирлага дохиоллын панель /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	29,600,000.00
18	Удирдлагын болон ХХБ-ын барилга /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	220,520,063.00
19	РП-ний барилга /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	96,643,113.00
20	ХТП-1 барилга /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	76,287,629.00
21	ХТП-2 барилга /Бугат/	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	76,287,629.00
22	Хүчдлийн трансформатор 35/10 кВ ХБ доторхи	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	9,000,000.00
23	Төв дохиоллын панель 35/10 кВ ХБ доторхи	2014	2015	Хөвсгөл аймгийн ЗДТГ	"Биндэгноров" ХХК	2014/84-А-01	УКА-34/2015	35,800,000.00
	<b>Нийт дүн</b>							<b>3,579,344,345.00</b> (гурван тэрбум таван зуун далан есөн сая гурван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун дөчин таван)